



АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үг, хүснэгтэн мэдээллийн жагсаалт	3
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4
ҮАГ-ын Нийцлийн аудитын газар	Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт	4
Газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Б.Алтанзул	Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа	5
	Үндсэн мэдээлэл	5
Аудитын менежер Х.Болдбаатар	Бүлэг 1. Сонгуулийн зардлыг төлөвлөх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байна	6
Ахлах аудитор Я.Наранцэцэг	Монгол улсын ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын төлөвлөлтийг хуулийн дагуу хийсэн байна	6
Аудитор Д.Дорждулам Л.Нямтөмөр	Засгийн газрын нөөц сангаас 2 дахь санал хураалтад шаардагдах зардлыг 7.2 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр нэмэлт зардал гаргасан байна	7
	Сонгуулийн хороод батлагдсан төсвийн 98.3 хувийг ээлжит сонгуулийг зохион байгуулахад зарцуулсан байна	7-11
2018 оны 2 дугаар сар 2	Бүлэг 2. Сонгуулийн зардлын гүйцэтгэлд тавих хяналтын тогтолцоо бүрдээгүй байна	12
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261729, 260949 дугаарын утсаар харилцана уу.	Зарим аймагт анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад гүйлгээ хийсэн, зохих шатны байгууллагын зөвшөөрөлгүйгээр зардал хооронд шилжүүлсэн, журамд заасны дагуу зарцуулаагүй зөрчил гаргасан байна	12
	СЭХ-ны хувьд батлагдсан бүтэц, орон тоогоор сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт тавих боломж бага, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо байнгын бус ажиллагаатай учраас хууль, журмын дагуу хяналт тавих боломж хангалтгүй байна	12-13
Хаяг: Үндэсний Аудитын газар Чингэлтэй дүүрэг Засгийн газрын 4 дүгээр байр Бага тойруу-3 Улаанбаатар 15160 Монгол Улс	Холбогдох байгууллагын санал	14
	Дүгнэлт, зөвлөмж	15
	Монгол Улсын Ерөнхий аудиторовн тушаал	16



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ЗГ	Засгийн газар
УИХ	Улсын Их Хурал
МУ	Монгол Улс
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МТБ	Мэдээлэл технологийн баг
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
СЕХ	Сонгуулийн Ерөнхий хороо
СХ	Сонгуулийн хороо
СД	Сум дүүрэг
ХАОАТ	Хүн амын орлогын албан татвар
УБСЕГ	Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар
ICP	Сонгуулийн автоматжуулсан систем

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт №1	МУ-ын Ерөнхийлөгчийн 2009, 2013, 2017 оны сонгуулийн ерөнхий тоон үзүүлэлт
Хүснэгт №2	Сонгуулийн зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэл
Хүснэгт №3	Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан зардлын төрлөөр төлөвлөгөө, гүйцэтгэл
Хүснэгт №4	Хоёр дахь санал хураалтын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл
Хүснэгт №5	Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны батлагдсан төсөв, зарцуулалт
Хүснэгт №6	Акт албан шаардлага, зөрчлийн жагсаалт



Аудитын зорилт

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2017 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбоотой төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүнг шалгаж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн батлагдсан төсвийг сонгуулийн хороодод холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилж, зарцуулсан эсэх;
- Сонгууль зохион байгуулах зардалд холбогдох хууль, журамд нийцүүлэн хяналт тавьсан эсэх.

Хамарсан хүрээ

Аудитаар Сонгуулийн ерөнхий хороо, аймаг, нийслэл, сум, дүүргийн Сонгуулийн хороод, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрыг хамрууллаа.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 4100 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журам, аудитын арга зүйг баримтлан сонгууль зохион байгуулахад зориулан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх аргуудыг ашиглан аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт зөвлөмж боловсрууллаа.

Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журамд заасны дагуу аудитын дүгнэлт, зөвлөмжид дэмжлэг болохуйц нотлох зүйлс, холбогдох бусад материалыг ажлын баримтад хавсаргав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

- Захиргааны ерөнхий хууль;
- Сонгуулийн тухай хууль;
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль;
- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- СЕХ-ны 2016 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”;
- СЕХ-ны 2016 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагад ажиллах ажилтны мэдээллийн сан бүрдүүлэх, сургалт зохион байгуулах, гэрчилгээ олгох журам”.



Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Б.Алтанзул удирдаж, аудитын менежер Х.Болдбаатар үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Я.Наранцэцэг, аудитор Д.Дорждулам, Л.Нямтөмөр нар болон аймаг, нийслэл дэх төрийн аудитын газрууд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу талбарын ажлыг гүйцэтгэж, нэгдсэн тайланг 2017 оны 11 дүгээр сарын 1-нд УИХ-д хүргүүлэхээр төлөвлөсөн.

Сонгуулийн Ерөнхий хорооны 2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 324 дүгээр албан тоотой ирүүлсэн 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн зарим гэрээт ажлын хугацаа 12 сард дуусгавар болох бөгөөд сонгуулийн баримт бичиг, саналын хайрцагны хадгалалт хамгаалалтыг шалгах ажилтай холбоотойгоор зардлууд гарч дуусаагүй тухай хүсэлт нь Төсвийн тухай хуульд заасан үндэслэлтэй байсан тул МУЕА-ын тушаалаар аудит хийх хугацааг хойшлуулж 2018 оны 3 дугаар сарын 1-ны өдөр хүртэл сунгасан болно.

Үндсэн мэдээлэл

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3¹ дахь заалт, Сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтын дагуу Монгол Улсын Их Хурлын 2017 оны 13 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийг 2 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэхээр товлон зарлаж, санал авах ажиллагааг 6 дугаар сарын 26-ний өдөр явуулахаар, Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар байрладаг гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэний санал авах ажиллагааг 6 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд явуулахаар тус тус тогтоосон байна.

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасны дагуу УИХ-ын 2017 оны 14 дүгээр тогтоолоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн сонгогчдын бүртгэлийн үйл ажиллагаанд техник хэрэгсэлийг ашиглах, санал авах, тоолох үйл ажиллагаанд “New Image Cast” санал тоолох төхөөрөмжийг тус тус хэрэглэхийг зөвшөөрсөн байна.

Сонгуулийн Ерөнхий хорооны 2017 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах цаг хугацааны хуваарь батлаж түүний дагуу ажилласан байна.

Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч сонгогчдын олонхийн санал аваагүй бол анхны санал хураалтад оролцсон нийт сонгогчийн хамгийн олон санал авсан хоёр хүнийг дахин санал хураалтад оруулна” гэж заасны дагуу СЕХ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн хоёр дахь санал хураалтыг 7 дугаар сарын 7-ны өдөр явуулахаар 43 дугаар тогтоол гаргасан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулахад аймаг, нийслэлийн 22, сум, дүүргийн 339 сонгуулийн хороо, гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагааг зохион байгуулах төв болон салбар комисс, 1983 хэсгийн санал авах байр, мэдээллийн технологийн 30 баг ажиллаж, тэдгээрт нийт 25 мянга гаруй төрийн албан хаагчид хамрагдан ажиллажээ.

¹ УИХ Ерөнхийлөгчийн ба Улсын Их Хурал, түүний гишүүний сонгуулийг товлон зарлах;



**БҮЛЭГ НЭГ. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫГ ТӨЛӨВЛӨХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ
БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА**

**1.1. Монгол улсын ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгууль зохион
байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын
төлөвлөлтийг хуулийн дагуу хийсэн байна**

Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1²-д заасны дагуу СЕХ-ны саналыг үндэслэн Монгол Улсын Их хурал 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр 2017 оны төсвийн тухай хуулиар Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн зардлыг 14.9 тэрбум төгрөгөөр баталсан байна.

СЕХ Сонгуулийн тухай хууль, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулиудыг үндэслэн 2017 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах зардлыг өмнөх сонгуулийн зардлын гүйцэтгэл, инфляцийн түвшин, валютын ханшийн хэлбэлзэл, санал өгөх насны иргэд, ажиллах хүч, сонгуульд өрсөлдөх намуудын тоо зэргийг харьцуулан төлөвлөсөн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн зардлын төсвийн төслийг боловсруулахдаа Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2.2-38.2.19-д заасан зардлын ангиллын дагуу төлөвлөсөн байна. Төлөвлөлт хийхэд Сангийн сайдын 2008 оны 245, 2011 оны 132 дугаар тушаалын унаа болон томилолтын зардал тооцохоос өөр баримталдаг нарийвчилсан журам, аргачлал байхгүй байна.

МУ-ын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн санал өгөх насны иргэд, сонгуулийн хороодод ажиллах хүний тоо, төсвийн ерөнхий тоон мэдээллийн дүнг 2009, 2013 оны тоон мэдээлэлтэй харьцуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 1. МУ-ын Ерөнхийлөгчийн 2009, 2013, 2017 оны сонгуулийн
ерөнхий тоон үзүүлэлт

№	Үндсэн үзүүлэлт	2009 оны сонгууль	2013 оны сонгууль	2017 оны сонгууль
1	Хүн амын тоо	2 616 631	2 870 407	3 132 405
2	Сонгуулийн насны иргэний тоо	1 642 567	1 998 586	2 032 022
3	Нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчийн тоо	1 493 217	1 864 273	1 988 891 1 990 797*
4	Санал өгсөн сонгогчийн	Тоо	1 098 875	1 239 784
		Хувь	73.59	66.50
				1 357 788 1 207 787*
5	Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны тоо (тойргийн хороо)	22	22	22
6	Сум, дүүргийн сонгуулийн хорооны тоо (салбар хороо)	338	339	339
7	Санал авах байрны тоо (хэсгийн хороо)	1 698	1 896	1 983
8	Мэдээллийн технологийн багын тоо	-	31	30
9	Мэдээллийн технологийн даамлын тоо	-	2 271	2495
10	Гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажиллагааг зохион байгуулах, салбар комисс	-	-	46
11	Сонгуулийн нийт зардлын төлөвлөлт (сая төгрөг)	4,000.0	15,846.8	14,954.0 7,200.0*

² 38.1 дэх хэсэгт “Сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг хүн амын тоог сонгуулийн нутаг дэвсгэртэй харьцуулан гаргасан сонгуулийн төв байгууллагын саналыг үндэслэн УИХ тухай бүр батална”



Тайлбар: * Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн 2 дахь санал хураалттай холбоотой тоо баримт. Эх сурвалж: СЕХ-ноос эрхлэн гаргасан “МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн 1993-2017”

МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль, УИХ-ын 2012 оны 69 дүгээр тогтоолоор 2013 оны ээлжит сонгуулийг анх удаа автоматжуулсан системээр зохион байгуулснаар сонгуулийн зардал 15,846.8 сая төгрөг буюу 2009 оны сонгуулийн зардлаас 3.9 дахин өссөн ч 2017 оны сонгуулийн зардлын төсвийг 0.9 сая төгрөгөөр бууруулж төлөвлөсөн байна.

1.2. Засгийн газрын нөөц сангаас 2 дахь санал хураалтад шаардагдах зардлыг 7.2 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр нэмэлт зардал гаргасан байна.

СЕХ-ны 2017 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 43 дугаар тогтоолоор хоёр дахь санал хураалт явуулах өдрийг 2017 оны 7 дугаар сарын 7-нд хийхээр товлож, ЗГ-ын 2017 оны 182 дугаар тогтоолоор 2 дахь санал хураалтад шаардагдах зардлыг Засгийн газрын нөөц сангаас 7.2 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр нэмэлт зардал гаргасан байна.

СЕХ МУ-ын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахад зориулан улсын төсвөөс 14,954.0 сая, 2 дахь санал хураалтын зардалд 7,200.0 сая төгрөгийн санхүүжилтийг авснаас, СЕХ-нд 11,714.1 сая, Аймаг, нийслэлийн сонгуулийн хороодод 10,439.9 сая төгрөгийг хуваарилсан байна.

Хүснэгт 2. Сонгуулийн зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэл

/сая.төг/

	Нийт		СЕХороо		Аймаг, нийслэл		Хэмнэлт, хэтрэлт
	Төсөв	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл	
Ээлжит сонгууль	14,954.0	14,605.5	6,888.2	6,644.3	8,065.8	7,961.2	348.5
2 дахь санал хураалт	7,200.0	7,181.1	4,825.9	4,820.2	2,374.1	2,360.9	18.9
Нийт	22,154.0	21,786.6	11,714.1	11,464.5	10,439.9	10,322.1	367.4

Эх сурвалж: СЕХ-ны төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

1.3. Сонгуулийн хороод батлагдсан төсвийн 98.3 хувийг ээлжит сонгуулийг зохион байгуулахад зарцуулсан байна

Нийт батлагдсан төсвийн 98.3 хувь буюу 21,786.6 сая төгрөгийг ээлжит сонгууль болон 2 дахь санал хураалт зохион байгуулахад зарцуулж 367.4 сая төгрөгийг зарцуулаагүй үлдсэнийг СЕХ улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 3. Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан зардлын төрлөөр төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төг/

№	Үзүүлэлт, зардлын агуулга	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Нэр дэвшигчийн үнэмлэх, сонгуулийн штабын ажилтан, менежер, шадар туслагч, ухуулагч болон сонгуулийн ажиглагчийн үнэмлэх хэвлэх, хүргүүлэх зардал /Хуулийн 38.2.2/	18.7	17.2	1.5
2	Саналын хуудас хэвлүүлэх, хамгаалах, хүргүүлэх зардал /Хуулийн 38.2.4/	3,207.5	3,190.8	16.7
3	Сонгуулийн дүн, мэдээний маягт, бие даан нэр дэвшигчийн дэмжигч-сонгогчийн гарын үсэг цуглуулах маягт, сонгуулийн байгууллагын албан бичгийн хэвлэмэл хуудас хэвлэх, хүргүүлэх зардал /Хуулийн 38.2.5/	6.0	4.5	1.4
4	Тамга, тэмдэг, лац, саналын хуудас битүүмжлэн хадгалах уут бэлтгэх зардал /Хуулийн 38.2.6/	85.4	85.1	0.3



5	Санал авах, тоолох, дүн гаргах ажиллагаанд хэрэглэх техник, тоног төхөөрөмж, тэдгээрийн сэлбэг хэрэгсэл, программ хангамж худалдан авах, түрээслэх, ашиглах, хадгалах, хамгаалах, засвар үйлчилгээ хийх, тээвэрлэх болон даатгал, тусгай тэмдэглэл хийх хэрэгсэл, тэдгээрийг худалдан авах, түрээслэх, ашиглах, хамгаалах, хадгалах, засвар үйлчилгээ хийх, хэвлэх, үйлдвэрлэх, тээвэрлэх, хүргэх, татан авах зардал /Хуулийн 38.2.7/	1,915.0	1,830.0	85.0
6	Санал хураалтын дүнгийн мэдээ дамжуулах зардал /Хуулийн 38.2.8/	324.5	298.8	25.8
7	Саналын хайрцаг хийх, хүргэх, санал авах байрын болон санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал /Хуулийн 38.2.9/	400.0	393.6	6.4
8	Сонгуулийн хууль тогтоомж болон сонгууль зохион байгуулахтай холбогдсон эрх зүйн бусад акт, гарын авлага, сургалт, сурталчилгааны материал боловсруулах, хэвлэх, хүргэх зардал /Хуулийн 38.2.10/	642.3	633.4	8.9
9	Сонгуулийн байгууллагын ажилтан, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон сургалтын зардал /Хуулийн 38.2.11/	370.3	350.9	19.4
10	Сонгуулийн хууль тогтоомжийг сурталчлах болон сонгууль зохион байгуулах, түүний бэлтгэл ажлын явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах арга хэмжээний зардал /Хуулийн 38.2.12/	297.7	282.8	14.9
11	Сонгуульд нэр дэвшүүлсэн нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, зарцуулалтыг хянан шалгахад гарах зардал /Хуулийн 38.2.13/	2.0	0.0	2.0
12	Сонгуулийн байгууллагын ажилтан, мэдээллийн технологийн багийн болон ажлын хэсгийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал /Хуулийн 38.2.15/	4,796.0	4,758.1	37.9
13	Сонгуулийн байгууллагын бичиг хэрэг, шуудан, холбоо, унаа, албан томилолтын зардал /Хуулийн 38.2.16/	1793.4	1,726.2	67.1
14	Гадаад улсад байгаа иргэдийн санал авахтай холбогдон гарах зардал /Хуулийн 38.2.17/	531.1	509.8	21.3
15	Сонгуулийн байгууллагын үйл ажиллагааны зардал /Хуулийн 38.2.1/	139.0	128.8	10.2
ДҮН		14,528.8	14,210.0	318.8
16	Нэмэлт болон дахин санал хураах, ээлжит, ээлжит бус, нөхөн болон дахин сонгууль явуулах болон онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал, сонгууль зохион байгуулахтай холбогдсон бусад зардал /Хуулийн 38.2.14, 38.2.18, 38.2.19/	425.2	395.6	29.6
НИЙТ ДҮН		14,954.0	14,605.5	348.5

Эх сурвалж: СЕХ-ны төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Хүснэгт 4. Хоёр дахь санал хураалтын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төг/

№	Үзүүлэлт, зардлын агуулга	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Саналын хуудас хэвлүүлэх, хүргүүлэх зардал	3,022.0	3,017.4	4.6
2	Саналын хуудас битүүмжлэн хадгалах уут бэлтгэх зардал	2.7	2.6	0.1
3	Сонгуулийн автоматжуулах системийг хэрэглэхтэй холбоотой зардал	344.3	344.0	0.3



4	Санал хураалтын дүнгийн мэдээ дамжуулах зардал	209.3	207.9	1.3
5	Сонгуульд саналаа өгөхийг уриалсан реклам хийлгэх, дамжуулах, сурталчлах, сурталчилгааны зардал	84.3	83.2	1.1
6	Сонгуулийн байгууллагын ажилтан, мэдээллийн технологийн багийн болон ажлын хэсгийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	1,700.1	1,693.0	7.1
7	Сонгуулийн хороодын бичиг хэрэг, шуудан, холбоо, унааны зардал	238.0	236.2	1.8
8	Сонгуулийн байгууллагын үйл ажиллагааны зардал	3.4	3.3	0.1
9	Болзошгүй зардал	33.0	30.8	2.2
ДҮН		5,636.8	5,618.2	18.6
1	Улсын бүртгэлийн байгууллагын зардал	913.2	913.1	0.1
2	Цагдаагийн байгууллагын зардал	650.0	649.8	0.2
НИЙТ ДҮН		7,200.0	7181.1	18.9

Эх сурвалж: СЕХ-ны төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3³, 38.4⁴-д сонгууль зохион байгуулахтай холбогдсон зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж улсын бүртгэлийн байгууллага, цагдаагийн байгууллагын төсөвт тусгахаар зааж өгсөний дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт зардлыг суулгасан байна.

Сонгуулийн тухай хуулийн 38.2.14, 38.2.18, 38.2.19-д заасан зардлыг нэг ангилалд багтааж төлөвлөсөн нь зардал хооронд шилжүүлж зарцуулах, зардлын ангиллын дагуу зарцуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал:

Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2.19-д заасан “сонгууль зохион байгуулахтай холбогдсон бусад зардал” гэсэн ангиллаар Онцгой байдлын ерөнхий газарт 40.0 сая, Хил хамгаалах ерөнхий газарт 46.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

-ОБЕГ гол мөрөн гаталж санал өгөх иргэдийн аюулгүй байдлыг хангах хүн хүч, техник хэрэгсэлд, Хил хамгаалах ерөнхий газар хилийн застав, харуулд үүрэг гүйцэтгэж байгаа гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдыг сонгуулийн санал авах байр руу тээвэрлэн хүргэж санал өгүүлэхэд зориулан зарцуулсан

Сонгуулийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.11⁵, 70 дугаар зүйлийн 70.17⁶-д заасны дагуу сонгуулийн сурталчилгаа хийсэн хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдсан 32.2 сая төгрөгийн зардлыг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар 2017 оны 1/518 дугаар албан бичгээр санхүүжилт хүссэний дагуу СЕХ 04 дугаар хуралдааны тэмдэглэлээр сонгуулийн зардлаас санхүүжүүлэхийг зөвшөөрсөн шийдвэр гаргасан байна.

³ 38.3.Сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, улсын бүртгэлийн байгууллагын төсөвт тусгана:

⁴ 38.4.Сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, цагдаагийн байгууллагын төсөвт тусгана:

⁵ 68.11.Энэ хуулийн 68.6, 68.7-д заасныг зөрчсөн хэвлэл, мэдээллийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шударга өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн тухайн зөвшөөрөл олгосон байгууллага зөрчил гарсан өдрөөс эхлэн зургаан сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ.

⁶ 70.17.Энэ хуулийн 70.1.6, 70.7-д заасныг зөрчсөн хэвлэл, мэдээллийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шударга өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн тухайн зөвшөөрөл олгосон байгууллага зөрчил гарсан өдрөөс эхлэн зургаан сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ.



Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын чиг үүрэгтэй холбоотой зардал тусгагдаагүй мөн Төсвийн тухай хуулиар зохицуулагдаагүй байна.

Аудитын хугацааг сунгаснаас хойш СЕХ-нд ээлжит сонгуулийн үеэр хэрэглэсэн санал тоолох, дүн гаргах ИСР төхөөрөмжид хадгалагдсан зурган файлыг CD-нд буулгах, төхөөрөмжийг цэвэрлэх, дараагийн сонгуулийн санал хураалтад бэлтгэх засварын ажлыг гүйцэтгэх гэрээт ажилтнуудын зардал, томилолт, унааны зардалд 42.8 сая төгрөгийг гаргаж тайлагнасан байна.

СЕХ сонгуулийн зардлыг аймаг, нийслэлд хуваарилахдаа сонгогчийн тоо, газар нутгийн хэмжээ, байршил, сум, дүүргийн сонгуулийн хорооны тоо, санал авах байрны тоо, тэдгээрт ажиллах сонгуулийн хорооны гишүүн, зохион байгуулагч, мэдээллийн технологийн ажилтны тоо, нэр дэвшигчийн тоо зэргийг харгалзан хуваарилжээ.

Хүснэгт 5. Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны батлагдсан төсөв, зарцуулалт
/сая.төг/

№	Аймаг, нийслэлийн СХ-ны нэр	СД-ийн СХороо	Хэсгийн тоо	Ээлжит сонгууль			2 дахь санал хураалт		
				Төсөв	Гүйцэтгэл	Буцаан төвлөрүүл сэн	Төсөв	Гүйцэтгэл	Буцаан төвлөрүүл сэн
1	Архангай	19	102	383.1	381.7	1.4	136.1	135.0	1.1
2	Баян-Өлгий	13	89	336.6	336.6	0.0	127.0	127.0	0.0
3	Баянхонгор	20	105	415.1	413.0	2.1	154.8	149.2	5.6
4	Булган	16	67	291.3	282.8	8.5	103.8	101.0	2.8
5	Говь-Алтай	18	79	325.0	323.9	1.1	112.6	112.5	0.1
6	Говьсүмбэр	3	9	52.5	52.5	0.0	16.5	16.5	0.0
7	Дорноговь	14	60	246.3	244.4	1.9	83.3	82.8	0.5
8	Дорнод	14	69	260.3	260.3	0.0	86.8	86.8	0.0
9	Дундговь	15	46	207.4	201.7	5.7	68.6	64.5	4.1
10	Завхан	24	113	454.4	454.4	0.0	167.3	167.3	0.0
11	Өвөрхангай	19	108	409.4	408.6	0.8	147.0	147.0	0.0
12	Өмнөговь	15	54	244.4	243.4	1.0	83.7	82.8	0.9
13	Сүхбаатар	13	59	234.5	233.9	0.6	78.3	78.2	0.1
14	Сэлэнгэ	17	58	268.4	255.3	13.1	95.7	91.5	4.2
15	Төв	27	84	379.2	360.3	18.9	136.0	128.1	7.9
16	Увс	19	91	341.0	340.5	0.5	120.0	120.0	0.0
17	Ховд	17	92	365.8	363.2	2.6	135.8	134.3	1.5
18	Хөвсгөл	23	122	488.8	479.0	9.8	177.2	171.4	5.8
19	Хэнтий	18	91	341.4	334.7	6.7	119.2	117.1	2.1
20	Дархан-Уул	4	39	160.1	137.5	22.6	55.6	53.4	2.2
21	Орхон	2	43	159.3	159.3	0.0	56.6	56.6	0.0
22	Нийслэл	9	403	1,701.0	1,693.6	7.4	139.5	137.8	1.7
	Нийт дүн	339	1983	8,065.8	7,961.3	104.5	2,401.8	2,360.9	40.9

Эх сурвалж: СЕХ-ны төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Ерөнхийлөгчийн сонгуулийг явуулахад аймаг, нийслэлийн Сонгуулийн хороонд олгосон 8,065.8 сая төгрөгийн санхүүжилтээс 7,961.3 сая төгрөг буюу 98.7 хувийг зарцуулж, үлдэгдэл 104.5 сая төгрөгийг Төв төрийн сан дахь СЕХ-ны 100900022001 тоот дансанд, 2 дахь санал хураалтын 2,401.8 сая төгрөгийн санхүүжилтээс 2,360.9




сая төгрөг буюу 98.2 хувийг зарцуулж, үлдэгдэл 40.9 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн 100900022401 тоот дансанд тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

График 1. Аймаг, нийслэлийн сонгуулийн хороодын хуваарилсан зардлын ангиллыг тоймлож график дүрслэлээр харуулбал:



Аймаг, нийслэлийн сонгуулийн хороодын зардлын гүйцэтгэлийн 54.3 хувь буюу 4,328.8 сая төгрөгийг сонгуулийн байгууллагын болон МТБ даамлын ажилтнуудын урамшуулалд, 4.9 хувь буюу 393.4 сая төгрөгийг санал авах байрыг тохижуулахад, 9.2 хувь буюу 739.2 сая төгрөгийг тээвэр шатахуун, унааны зардалд, 4 хувь буюу 323.3 сая төгрөгийг сургалтын зардалд, 27.3 хувь буюу 2,176.4 сая төгрөгийг бусад зардалд зарцуулсан байна.

График 2. Бусад зардал буюу 2,176.4 сая төгрөгийг задлаж харуулбал:



2,176.4 сая төгрөг буюу бусад зардалд маягт бөглөх 4.5, бичиг хэрэгт 438.9, шуудан холбоо 422.8, сурталчилгаанд 205.4, сурталчилгааны материал хүргүүлэхэд 48.4, саналын хуудас устгахад 15.1, саналын хуудас хүргэхэд 91.7, ICP машиныг хүлээн авахад 233.0, МБТ-ийн мэдээ дамжуулахад 82.5, томилолтын зардалд 88.7,



эрчим хүчний эх үүсвэрт 73.9, болзошгүй зардалд 144.3, сонгуулийн байгууллагын болон МТБ, даамлын урамшуулалд 327.0 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

Хоёр дахь санал хураалтын аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны 2,360.8 сая төгрөгийн зардлын гүйцэтгэлд бичиг хэрэгт 38.7, шуудан холбоонд 48.2, унааны зардалд 149.2, саналын хуудас хүргэхэд 85.0, ICP машиныг хүлээн авахад 181.9, МБТ-ийн мэдээ дамжуулахад 83.0, эрчим хүчний эх үүсвэрт 71.4, хоолны зардалд 336.0, санал авах байранд 5.3, болзошгүй зардалд 5.4, сонгуулийн байгууллагын ажилтны урамшуулалд 1,356.7 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.



**БҮЛЭГ ХОЁР. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ТАВИХ ХЯНАЛТЫН
ТОГТОЛЦОО БҮРДЭЭГҮЙ БАЙНА**

2.1. Зарим аймагт анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад гүйлгээ хийсэн, зохих шатны байгууллагын зөвшөөрөлгүйгээр зардал хооронд шилжүүлсэн, журамд заасны дагуу зарцуулаагүй зөрчил гаргасан байна

Аудитын явцад аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороод МУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах зардлыг холбогдох хууль, заавар журмын дагуу зарцуулаагүй зөрчлийг арилгуулахаар Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12⁷-т заасны дагуу төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгуулах албан шаардлага өгсөнийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 6. Акт албан шаардлага, зөрчлийн жагсаалт

/сая.төг/

№	Сум, дүүргийн Сонгуулийн хороо	Акт	Албан шаардлага	Зөрчлийн агуулга
1	Баян-Өлгий	2.9		Төсөв хэтрүүлж урамшуулал илүү олгосон;
2	Говь-Алтай	2.8	68.9	Зориулалт бусаар зарцуулсан, батлагдсан нормоос хэтрүүлсэн, анхан шатны баримтгүй ажил гүйлгээ, суутгал хийгээгүй ажил, гүйлгээ бүртгэсэн, зардал хооронд гүйлгэж зарцуулсан;
3	Говьсүмбэр	0.7		Анхан шатны баримтгүй;
4	Дорноговь	0.2	0.1	Томилолтын зардал илүү олгосон;
5	Дундговь	0.2		Зориулалт бусаар зарцуулсан;
6	Орхон	0.7	1.7	Тээврийн зардлыг илүү тооцож олгосон;
7	Сүхбаатар	11.8		Зориулалт бусаар зарцуулсан;
8	Сэлэнгэ	-	74.0	Анхан шатны баримтын бүрдэл дутуу, зардлын ангилал хооронд гүйлгэж зарцуулсан;
9	Увс	1.0		ХАОАТ-ыг суутгаагүй;
10	Ховд	7.8	7.5	ХАОАТ суутгаагүй, томилолт буудлын зардал илүү олгосон;
11	Хөвсгөл		5.2	Зардал хооронд гүйлгэж зарцуулсан;
	Нийт дүн	28.4	157.4	

Эх сурвалж: Аймаг, нийслэлийн төрийн аудитын газрын “МУ-ын Ерөнхийлөгчийн 2017 ээлжит сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл” нийцлийн аудитын тайлангаас

Аудитын явцад 28.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад гүйлгээ хийсэн, зохих шатны байгууллагын зөвшөөрөлгүйгээр зардал хооронд шилжүүлсэн, журамд заасны дагуу зарцуулаагүй зөрчилд 157.4 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өгсөн байна.

Аймаг, нийслэлийн Сонгуулийн хороод холбогдох журам, зааврын дагуу баримт, материалыг архивт, мөн төрийн сангийн архивт тус тус шилжүүлсэн байна.

2.2. СЕХ-ны хувьд батлагдсан бүтэц, орон тоогоор сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт тавих боломж бага, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо байнгын бус ажиллагаатай учраас хууль, журмын дагуу хяналт тавих боломж хангалтгүй байна.

⁷ Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих;



МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлыг батлагдсан хэмжээнд зарцуулсан ч зарим аймагт анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад гүйлгээ хийсэн, зохих шатны байгууллагын зөвшөөрөлгүйгээр зардал хооронд шилжүүлсэн, журамд заасны дагуу зарцуулаагүй зөрчил гаргасан байна.

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5⁸, 13 дугаар зүйлийн 13.1.2⁹-д заасны дагуу мөн СЕХ-ны 2016 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-д зааснаар СЕХ, аймаг, нийслэлийн Сонгуулийн хороод “сонгуулийн зардлын зарцуулалтад” хяналт тавих зохицуулалтай байгаа боловч хэрэгжүүлж ажиллах боломж хангалтгүй байна.

Сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4¹⁰, 24.5¹¹-д заасны дагуу СЕХ байнгын бус ажиллагаатай, аймаг нийслэлийн сонгуулийн хороодод нягтлан бодогчийн мэргэжилтэй хүн ажиллуулах чиглэл өгч ажиллаж байгаа ч сумдын сонгуулийн хороодод нягтлан бодогч ажиллах боломжгүй байгаа зэргээс шалтгаалан хяналт хангалтгүй байна.

СЕХ батлагдсан бүтэц, орон тоо, хүний нөөцөөр сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт тавих боломж бага, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1¹²-д заасны дагуу дотоод аудитын ажлын алба болон дотоод аудитор ажиллууллагагүй байна.

-СЕХ-ны 2013 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан бүтэц, орон тоонд дотоод аудитын орон тоо байхгүй, 2018 оны төсөвт 7 орон тоо нэмүүлэх санал өгсөн ч ОУВС-гаас тавьсан шаардлага, УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоол гарсантай холбоотойгоор дэмжигдээгүй байна.

СЕХ, аймаг, нийслэлийн, сум, дүүргийн сонгуулийн хороо сонгуулийн зардалд тавих хяналтыг Захиргааны ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-д “үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хүний нөөц, эсхүл бүтэц, тогтолцоо бодитоор дутагдсан бол захиргааны байгууллага бусад захиргааны байгууллагаас туслалцаа авч болно” гэж заасны дагуу, эсвэл Төсвийн тухай хуулийн 14.4¹³-д заасны дагуу төсвийн зардалд хяналт тавих эрхээ тухайн орон нутгийн төвлөрүүлэн захирагч болон тухайн дотоод аудитын албаар хяналт тавиулах боломж байгаа эсэхийг судалж шийдвэрлэх шаардлага харагдаж байна.

Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журмын 3.5-д “СЕХ нь сонгуулийн хороодын зардлын дансыг Сангийн яамны Төрийн сангийн газарт нээлгэн, сонгууль дууссаны дараа зохих журмын дагуу хаалгана” гэж заасны дагуу аймаг, нийслэлд данс нээж үйл ажиллагаа явагдаж байгаа ч хяналт тавих чиглэлээр эрх зүйн зохицуулалтгүй байна. Тухайлбал:

⁸ 7.1.5.ард нийтийн санал асуулгын болон сонгуулийн зардлын төсвийг батлагдсан хэмжээний дотор хуваарилах, зарцуулалтад хяналт тавих;

⁹ 13.1.2.сонгуулийн хороодын санхүүгийн тайланг хянан шалгах;

¹⁰ 24.4.Сонгуулийн төв байгууллага нь байнгын ажиллагаатай төрийн байгууллага байна.

¹¹ 24.5.Сонгуулийн төв байгууллагаас бусад сонгуулийн байгууллага нь байнгын бус ажиллагаатай байх бөгөөд энэ хуульд өөрөөр заагаагүй бол байгуулсан этгээд татан буулгах тухай шийдвэр гаргаснаар үйл ажиллагаа нь дуусгавар болно.

¹² Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.

¹³ 14.4.Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.



Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлээр Төрийн сангийн нийтлэг чиг үүргийг заахдаа төсвийн хэрэгжилтийг зохион байгуулж, түүнд хяналт тавихаар заасан боловч улсын төсвөөс санхүүжигдэж байгаа сонгуулийн зардалд хяналт тавих эрх зүйн зохицуулалтгүйгээс сонгуулийн зардалтай холбоотой баримт аймаг, нийслэлийн төрийн санд хяналт тавигдахгүй архивлагдаж байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



**МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО**

15141 Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг,
Ж Самбуугийн гудамж 11, Засгийн газрын XI байр.
Утас: 28 09 75, Факс: (076-11) 32 69 75,
E-mail: gesm@gec.gov.mn http://www.gec.gov.mn

2018.02.07 № 19


танай _____-ны № _____-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны
ээлжит сонгуулийн зардлын гүйцэтгэлд хийсэн
аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Төсөлд тусгайлан өгөх саналгүй байна.

ДАРГА



Ч.СОДНОМЦЭРЭН

000020



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн зардлын төсвийн төслийг боловсруулахдаа Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2.2-38.2.19-д заасан зардлын ангиллын дагуу төлөвлөсөн ч, баримталдаг нарийвчилсан журам, аргачлал байхгүй байна.
- Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын чиг үүрэгтэй холбоотой зардал тусгагдаагүй мөн Төсвийн тухай хуулиар зохицуулагдаагүй байхад зардал гарсан байна.
- СЕХ, аймаг, нийслэлийн, сум, дүүргийн сонгуулийн хороо сонгуулийн зардалд тавих хяналтыг Захиргааны ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-д “үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хүний нөөц, эсхүл бүтэц, тогтолцоо бодитоор дутагдсан бол захиргааны байгууллага бусад захиргааны байгууллагаас туслалцаа авч болно” гэж заасны дагуу, эсвэл Төсвийн тухай хуулийн 14.4-д заасны дагуу төсвийн зардалд хяналт тавих эрхээ тухайн орон нутгийн төвлөрүүлэн захирагч болон орон нутгийн дотоод аудитын албаар хяналт тавиулах боломжийг судалж шийдвэрлэх шаардлага байна.
- СЕХ батлагдсан бүтэц, орон тоо, хүний нөөцөөр сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт тавих боломж бага, Төсвийн тухай хуулийн дагуу дотоод аудитын ажлын алба болон дотоод аудитор ажиллууллагагүй байна.

Зөвлөмж


Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Сонгуулийн ерөнхий хорооны даргад:

- Ээлжит сонгуулийн зардлын төсвийг боловсруулахдаа зардлыг хийгдэх ажил бүрээр үйл явцын зураглалыг хийж, нарийвчилсан аргачлалыг боловсруулж төлөвлөх, сонгуулийн бус жил Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх зардлыг хэмнэх талаар нэгдсэн хяналт зохицуулалтын арга хэмжээ авч ажиллах,
- Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйл, Төсвийн тухай хуулиар зохицуулагдаагүй Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын чиг үүрэгтэй холбоотой гарах зардлын эрх зүйн зохицуулалтыг холбогдох газарт уламжилж шийдвэрлэх,
- СЕХ, аймаг, нийслэлийн, сум, дүүргийн сонгуулийн хороо сонгуулийн зардалд тавих хяналтыг Захиргааны ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, Төсвийн тухай хуулийн 14.4-д заасан дагуу тухайн орон нутгийн төсвийн төвлөрүүлэн захирагч болон дотоод аудитын албаар тавиулах боломжийг судалж шийдвэрлэх,
- СЕХ бүтэц, орон тоондоо Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу дотоод аудитын алба байгуулах, дотоод аудитор ажиллуулах арга хэмжээ авч ажиллах.



Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал



2018 оны 02 сарын 28

А/38


ХТ/2018/05-НА

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан Нийцлийн аудитын түр журмын 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын гүйцэтгэл”-д хийсэн нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталсугай.
2. Аудитын тайланг Сонгуулийн Ерөнхий хороонд хүргүүлсүгэй.
3. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2018 оны 12 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сонгуулийн Ерөнхий хороо /Ч.Содномцэрэн/-д зөвлөсүгэй.
4. Аудитын зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудиторт даалгасугай.
5. Аудитын тайланг баталсан өдрөөс хойш 30 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудиторт, энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч бөгөөд тэргүүлэх аудитор /С.Оюунбилэг/-т тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ